



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/15

Эрдэнэт

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019 оны давсан орлогоос байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор авсан Тоёота хайс маркийн 27,800,000 (хорин долоон сая найман зуун мянга) төгрөгийн балансын өртөгтэй, 3,839,888.9 (гурван сая найман зуун гучин есөн мянга найман зуун наян найман төгрөг есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй суудлын автомашиныг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Оюунгэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ